

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

- а. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.**
б. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

- Дээд палеолитын үед гарсан дэвшил аль нь вэ? (1 оноо)
 А. Хадны зураг В. Гал
 С. Нум сум D. Үйлдвэрлэх аж ахуй E. Хүрэл зэвсэг
- Дунд палеолитын үед багаж зэвсэгт ямар дэвшил гарсан бэ? (2 оноо)
 А. Модны уян харимхай чанарыг ашиглан нум сум зохион бүтээсэн.
 В. Зэсийг хорголжин тугалгатай хольж хүрэл боловсруулж эхэлсэн.
 С. Үзүүр мэсийг ишинд бэхэлж жад хийх болсон.
 D. Үлдэц, цуулдас гаргах аргаар чулуун зэвсэг хийх болсон.
 E. Шавар ваар, сав хийж хэрэглэх болсон.
- Монгол нутагт үйлдвэрлэх аж ахуй үүссэнээр хүмүүс гөрөөчлөн тэнүүчлэх нь цөөрч, суурин хэв маягийн амьдралд шилжиж байсныг гэрчлэх нүх ухах байгуулсан, өрхөөр нь орж гардаг, модон багана, шалтай газар сууцууд хаанаас олдсон бэ? (1 оноо)
 А. Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул
 В. Ховд аймгийн Манхан сумын Хойд цэнхэрийн агуй
 С. Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мойлтын ам
 D. Дорнод аймгийн Халхгол сумын Тамсагбулаг
 E. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй
- Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.
 Монгол орны төв, баруун хэсэгт өргөн тархсан хүрэл, түрүү төмрийн үеийн тахилга ба оршуулгын байгууламжийг гэнэ. (1 оноо)
 А. Шоргоолжин булш В. Буган хөшөө
 С. Хадны зураг D. Дөрвөлжин булш E. Хиргисүүр
- Монгол нутагт эртний хүмүүс хүрлийн үе, түрүү төмрийн үеэс өөр хоорондоо зөрчилдөх болжээ. Зөрчилдөх болсон гол шалтгааныг тодорхойлно уу. (1 оноо)
 А. Хүн ам, малын тоо нэмэгдэж бэлчээр, гөрөөлөх нутгийн хүрэлцээ багассан.
 В. Хэл ярианд суурилсан харилцаа хөгжсөнөөр хүмүүс мэдлэгээ солилцох болсон.
 С. Газар тариалан эрхлэгчдийн тоо нэмэгдэж үржил шимтэй нутгийн хэмжээ багассан.
 D. Торгоны замд нөлөөллөө тогтоох өрсөлдөөн нэмэгдсэн.
 E. Зөөлөн чийглэг уур амьсгалтай болсноор тариалан эрхлэгчдийн тоо нэмэгдсэн.
- Хүннү гүрний шаньюй нарыг төр барьсан онтой нь зөв харгалзуулна уу. (1 оноо)
 1. Модунь шаньюй a. НТӨ 161-126 он
 2. Гүнчин шаньюй b. НТӨ 209-174 он
 3. Гиюй (Лаошан) шаньюй c. НТӨ 174-161 он
 А. 1b2c3a В. 1a2b3c С. 1c2a3b D. 1b2a3c E. 1c2b3a
- Хүннүгийн баруун өмнө, Хятадаас чанх баруун тийш 10 000 ли /5000 км/ газарт Даюань /Дундад азийн Ферганы хөндий/ бий. 1 ли хэдэн км-тэй тэнцэх вэ? (2 оноо)
 А. 0.05 км В. 2 км С. 0.5 км D. 5000 км E. 15 000 км
- Сяньби угсааны улсыг олно уу. (1 оноо)
 А. Хань улс В. Тоба Вэй улс
 С. Түрэг улс D. Уйгур улс E. Цинь улс



9. “Эмэгтэйчүүд нь хатгамал хатгана, эсгий оёж ширдэг хийнэ. Эрэгтэйчүүд нь нум сум, эмээл хазаар хийдэг” гэсэн сурвалжийн мэдээ нь ямар аж ахуйн талаар өгүүлж байна вэ? (1 оноо)
- A. Газар тариалан B. Гар урлал
C. Мал аж ахуй D. Ан гөрөө E. Худалдаа, арилжаа
10. “Хүннүгийн хүн ам Хань улсын нэг тойрогт хүрэхгүй. Хүчирхэг байгаагийн шалтгаан нь хувцас хунар, хоол, идээ өөр. Хань (Хятад)-д түшиглэхгүйн учир болой” гэсэн сурвалжийн мэдээ нь ямар утга санаа илэрхийлж байна вэ? (1 оноо)
- A. Хүннү улс Хань улсад түшиглэдэг байсан учир хүчирхэг байсан.
B. Хань улсын хүн ам Хүннүгээс олон байсан учир хүчирхэг байсан.
C. Хүннү нар Хань улстай хувцас хунар, хоол, идээ ижил байсан.
D. Хүннү улс нийгэм, соёлын хувьд бие даасан хүчирхэг улс байсан.
E. Хүннү нар Хань улсын хүн амаас цөөн байсан учир хүчирхэг биш байсан.
11. Хүннү нарын олонх нь ямар шашин, шүтлэгтэй байсан бэ? (1 оноо)
- A. Манихейн шашин B. Бурхны шашин
C. Исламын шашин D. Загалмайн шашин E. Бөөгийн шашин
12. Төв аймгийн Борнуур сумын Ноён уулын язгууртны булшнаас Грек домгийн бурхад дүрсэлсэн мөнгөн эдлэл олдсон нь юуг илэрхийлж байна вэ? (1 оноо)
- A. Хүннү гүрэн өрнийн орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаатай байсан.
B. Грекчүүд, Хүннү гүрэнд жил бүр алба барьдаг байсан.
C. Хүннү гүрэн, Гректэй хиллэдэг байсан.
D. Хүннү гүрэн, Гректэй байлдаж байсан.
E. Модунь шаньюй Грект айлчилж байсан.
13. X-XII зууны ихэнх Монгол аймгууд ямар шашин шүтлэгтэй байсан бэ? (1 оноо)
- A. Буддын шашин B. Загалмайн шашин
C. Исламын шашин D. Бөөгийн шашин E. Манихейн шашин
14. 1135 онд Хабул хан Алтан улсад айлчилжээ. Энэ үйл явдал хэддүгээр зуунд хамаарахыг тооцоолно уу. (2 оноо)
- A. X зууны I хагас B. XI зууны I хагас
C. XII зууны I хагас D. XI зууны II хагас E. XII зууны II хагас
15. “Татар хүний бие бялдар өндөр бус, хамгийн өндөр нь таван тохой хоёр гурван ямхаас давахгүй” гэсэн сурвалжийн мэдээг ашиглан татар хүний өндрийг тооцоолон олно уу. /нэг тохой 35 см орчим, ямх-3.2 см/ (2 оноо)
- A. 156.4-159.6 см B. 181.4-184.6 см
C. 171.4-174.6 см D. 175-178.2 см E. 176.4-179.6 см
16. Их Монгол улс нэгэн зэрэг хоёр хаантай байсан үеийг олно уу. (1 оноо)
- A. 1229-1241 он B. 1260-1264 он
C. 1241-1246 он D. 1246-1248 он E. 1251-1259 он
17. Юань улс хүн амаа дөрвөн зэрэгт хуваажээ. Тэргүүн зэрэгт ямар хүн хамаарах вэ? (1 оноо)
- A. Өнгөт нүдтэн хүн B. Зүрчид, Хятан
C. Нанхиад хүн D. Монгол хүн E. Умард хятадын хүн



18. Алтан орд улсын газар нутгийг зөв тодорхойлно уу. (1 оноо)
 А. Өнөөгийн Иран, Ирак, Солонгос, Хятадын нутаг
 В. Или голын сав, Долоон гол, Кашгарын нутаг буюу Хуучин Хар Хятаны нутаг
 С. Өнөөгийн Иран, Ирак, Азербайжан, Армян, Гүрж, Турк, Сирийн хойд хэсэг Афганистаны баруун хэсэг
 D. Монгол, Төвөд, Солонгос, Хятадын нутаг
 E. Дорно зүг Эрчис мөрөн, өрнө зүгт Дунай мөрний доод урсгал, өмнө зүгт Кавказын нуруу, хойд зүгт Ижил мөрөн хүртэл
19. Даалгаврыг гүйцэтгэхдээ дараах томъёог ашиглаарай. (X=M-M/33+622)
 Зоосны нүүрэн талд “Аугаа их Султан Тогтох”, нөгөө талд бурхны авралд Сарай хотод 710 онд цутгав” гэжээ. Хижрийн тооллын 710 оныг аргын тоололд шилжүүлнэ үү. (2 оноо)
 А. 1311 он В. 55 он С. 1365 он D. 1332 он E. 655 он
20. Аюушридар хааны төр барьсан он аль нь вэ? (1 оноо)
 А. 1400-1402 он В. 1378-1388 он
 С. 1393-1399 он D. 1370-1378 он E. 1403-1412 он
21. Улс төрийн бутралын үеийн Зүүн Монголын зүүн гарын гурван түмнийг зөв ялгасныг олно уу (2 оноо)
 1. Ордос 2. Халх 3. Урианхай 4. Түмэд 5. Юншээбүү 6. Цахар
 А. 2,4,5 В. 1,4,5 С. 2,3,6 D. 1,2,3 E. 4,5,6
22. Мин улс Монгол улстай худалдаа хийхдээ зөвхөн нас залуу агт морьд, үржлийн насны гүүгээр арилжаа хийдэг байжээ. Энэ нь ямар зорилготой байсан бэ? (2 оноо)
 А. Худалдааны салбарт адуу ашиглан бараа таваар тээвэрлэх
 В. Газар тариалангийн салбарт адууны хүчийг ихээр ашиглах
 С. Монголчуудын цэрэглэх чадварыг бууруулах, адуун сүргийн бүтцийг алдагдуулах
 D. Мин улс барууны улс орнуудтай адуугаар худалдаа хийх
 E. Монголчуудад адуугаараа хятад бараа худалдан авах нь ашигтай байсан.
23. Хөх нуур, Төвөдийг эзэлж, Хошууд улсыг байгуулсан түүхэн зүтгэлтэн аль нь вэ? (1 оноо)
 А. Цогт Тайж В. Лигдэн хаан
 С. Галдан бошгот D. Гүүш хан Төрбайх E. Шолой Уваш
24. Соёмбо үсгийг хэн зохиосон бэ? (1 оноо)
 А. Агваан лам В. Зая бандида Намхайжамц
 С. Аюуш гүүш D. Пагва лам E. Өндөр гэгээн Занабазар
25. Түмэдийн Алтан ханы шашны цааз хэрэгжсэнээр монголчуудын ёс заншилд ямар өөрчлөлт гарсан бэ? (2 оноо)
 А. Сарын гурван бацгийн /мацаг/ өдөрт малын амь таслах буюу шувуу авлахыг тэвчих болсон.
 В. Хаад ноёд асар том гэр тэрэг хэрэглэх болсон.
 С. Хүн нас барвал чинээ чинээгээр тэмээ, морийг алж, хойлго хийх болсон.
 D. Монголчууд хүрээний зохион байгуулалтаар нүүдэллэх болсон.
 E. Эрчүүд тайван цагт мал аж ахуйгаа эрхлэн, дайн байлдааны үед бүгд цэрэг болдог.



26. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн дотоод хүчин зүйл аль нь вэ? (2 оноо)
 А. Төвөд, Мин улсын түрэмгийллээс өөрсдийгөө хамгаалахын тулд гаднаас цэрэг, эдийн засгийн тусламж хайж байжээ.
 В. XVI зууны сүүл үеэс бурхны шашны шар, улааны урсгалууд өөрсдийн нөлөөг дэлгэрүүлэхээр өрсөлдөх болжээ.
 С. Төвөд улсын шашны урсгалууд монголчуудаас цэрэг, эдийн засгийн дэмжлэг хайж байжээ.
 D. Монголын эрх баригчид улс орныхоо нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлэх зорилгодоо шашныг ашиглаж байжээ.
 E. Монголын мал сүрэг, алт мөнгө нь Төвөдийн шар, улааны урсгалуудад томоохон дэмжлэг болжээ.
27. Зүүнгар улс Манжид хэзээ эзлэгдсэн бэ? (1 оноо)
 А. 1636 он В. 1691 он С. 1755 он D. 1721 он E. 1688 он
28. 1689 оны Ар элстэйн чуулганаар Халхын ноёд ямар асуудлыг хэлэлцсэн бэ? (2 оноо)
 А. Өвөр Монголын 16 аймгийн ноёд Манж улсад дагаар орох асуудлыг хэлэлцсэн.
 В. Халхын ноёд Манжид дагаар орох асуудлыг хэлэлцсэн.
 С. Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг Халхын шарын шашны тэргүүнээр өргөмжлөх асуудлыг хэлэлцсэн.
 D. “Монгол-Ойрадын Их цааз” -ыг батлах асуудлыг хэлэлцсэн.
 E. Торгуудын Хо өрлөг, Дөрвөдийн Далай тайш нар харьяатаа авч нүүдэллэх асуудлыг хэлэлцсэн.
29. 1727 оны Буурын гэрээгээр Оросын хаант улсын мэдэлд бүрэн орсон монголчууд аль нь вэ? (1 оноо)
 А. Хотгойд В. Халимаг
 С. Өвөр Монгол D. Буриад Монгол E. Халх Монгол
30. Лигдэн хаан 1617 онд Авга хар ууланд ямар нэртэй хотыг байгуулсан бэ? (1 оноо)
 А. Байшин хот В. Хөх хот
 С. Шар бөсийн орд D. Хархорум хот E. Очир Цагаан хот
31. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн дотоод шалтгааныг олно уу. (2 оноо)
 А. Монголын их хааны сүр хүч буурч, эрх мэдлийн хуваарилалт алдагдсан.
 В. Мин улсын хагалан бутаргах бодлого нөлөөлсөн.
 С. Манж нар монголчуудыг их цэргээр удаа дараа довтолсон.
 D. Манж улс хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлогоо идэвхжүүлсэн.
 E. Хаант Орос улс газар нутгаа тэлэх бодлого явуулж байсан.
32. Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.
 1905 оны намар Өвөр монголын Жирмийн чуулганы өмнөд Горлос хошуунд
 удирдлагаар зэвсэгт бослого гарчээ. (1 оноо)
 А. Онолт В. Цогдалай
 С. Чингүнжав D. Тогтох тайж E. Энхтайван
33. Тогтох тайж ямар шалтгаанаас болж хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн пүүсийг эвдэн сүйтгэж, өрийн дансыг устгасан бэ? (2 оноо)
 А. 1756 онд Чин ван Эринчиндоржийг Амарсанаагийн хэрэгт холбогдуулан цаазаар авснаас болсон.
 В. Бүрни, Лувсан нар 1675 онд Манжийн ноёрхлыг эсэргүүцэн босож тэмцээд амь үрэгдсэн.
 С. Өвөр Монголд Хятадын мөнгө хүүлэгч, худалдаачдын мөлжлөг хэрээс хэтэрсэн.
 D. 1758 оны эцэс хүртэл Зүүнгарын босогчид хэсэг бүлгээр тулалдсанаас болсон.
 E. Зүүнгарын монголчуудыг олон арван мянгаар нь хядсан.



34. Манж амбан Сандо Хүрээнээс хэзээ хөөгдөн гарсан бэ? (1 оноо)
 А. 1911.11.30 В. 1911.12.04
 С. 1911.12.01 D. 1911.12.29 E. 1911.12.03
35. Монголчууд Улиастайг Манжийн эрхшээлээс хэзээ чөлөөлсөн бэ? (1 оноо)
 А. 1914.2 сард В. 1912.8 сард
 С. 1912.2 сард D. 1912.1 сард E. 1915.6 сард
36. Богд Хаант Монгол улсын анхны иргэний сургууль хэзээ байгуулагдсан бэ? (1 оноо)
 А. 1918 он В. 1914 он С. 1913 он D. 1915 он E. 1912 он
37. 1916 онд “Улсын хөрөнгийг захирах газар”-ыг байгуулжээ. Энэ Олноо өргөгдсөний хэддүгээр он бэ? (2 оноо)
 А. 6 дугаар он В. 5 дугаар он
 С. 7 дугаар он D. 16 дугаар он E. 17 дугаар он
38. Богдын тэргүүлсэн засгийн газрын үйл ажиллагаанд аль нь хамаарах вэ? (2 оноо)
 А. Цагаантны цэрэгт хүчин зүтгэж байсан монголчуудыг талдаа татах
 В. МАН, Түр засгийн төлөөний түшмэлийг хошуу, шавьд томилон суулгахаар шийдсэн.
 С. Ардын журамт цэргийг өргөтгөх хүч нөлөөгөө нэмэгдүүлэх
 D. АТЗГ-тай сөргөлдөж байсан тул яваандаа зэвсэгт мөргөлдөөнд зайлшгүй хүрнэ хэмээн бэлтгэлээ хангаж байсан.
 E. Цагаантны цэргийг хөөн зайлуулах тулд улаан цэргийн ангийг Монголд оруулах хүсэлтийг ЗОУ-д тавьсан.
39. Монгол улсын хөгжлийн талаарх Д.Бодоогийн үзэл баримтлал аль нь вэ? (1 оноо)
 А. Уламжлал, шинэчлэлийг хослуулах, ардчилсан чиг шугамыг баримтлах
 В. Монголд бүгд найрамдах засаг тогтоох, хүн төрөлхтний туулж ирсэн жам ёсны дагуу, шат дараалан хөгжих ёстой.
 С. Ардын эрхт, хэмжээт цаазат засаг тухайн цаг үед тохиромжтой
 D. Монгол улс социалист чиг баримжаагаар хөгжих
 E. Уламжлалт хэмжээгүй эрхт хаант засаглалтай байх
40. Ардын засгийн газраас гадаад байдлаа бэхжүүлэхийн тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ аль нь вэ? (2 оноо)
 А. “Тангарагийн гэрээ”-г батлан мөрдүүлсэн.
 В. С.Данзан тэргүүтэй монголын төлөөлөгчид Москвад айлчилсан.
 С. Эзэн, хамжлагын харилцааг халах шийдвэр гаргасан.
 D. “Улсын түр цагийн хурал”-ыг байгуулсан.
 E. Судар бичгийн хүрээлэн байгуулсан.
41. Монгол улс анхдугаар Үндсэн хуулиа хэзээ баталсан бэ? (1 оноо)
 А. 1924.06.07 В. 1924.11.26
 С. 1940.06.30 D. 1960.07.06 E. 1992.01.13
42. Анхдугаар Үндсэн хуулиар улс төрийн эрхээ хасуулаагүй хүмүүс аль нь вэ? (1 оноо)
 А. Урьдын ван, гүн В. Бусдыг хөлслөн аж ахуй эрхлэгчид
 С. Хутагт хувилгаад D. Жинхэнэ ард E. Ял шийтгэгдэгсэд



43. Шинэ эргэлтийн бодлогын үр дүн аль нь вэ? (2 оноо)
 А. Улс орныг удирдах хэрэгт намын үүрэг нэмэгдсэн.
 В. Ард иргэд хэвийн аж төрөх боломжгүй болсноос нутгаа орхин хил даван нүүж эхэлсэн.
 С. Нөхөрлөл, коммуна, артель, нэгдэл хэмээх дундын өмчтэй хоршоолол хэдэн зуугаар нь байгуулсан.
 D. Төрөөс худалдааны салбарт тавих хяналтыг хүчтэй болгон хувийн худалдааг хавчих болсон.
 E. Ард түмний шүтэх, бишрэх эрх чөлөөг сэргээж, лам нарыг албадан хар болгохоо зогсоосон.
44. Европт энх амгалан байдал ямар үйл явдлаар тогтсон бэ? (1 оноо)
 А. 1945 оны 5 сарын 9-нд Нацист Герман бууж өгсөн.
 В. 1945 оны 9 сарын 2-нд Япон үг дуугүй бууж өгөх актад гарын үсэг зурсан.
 С. 1945 оны 8 сарын 9-нд ЗХУ Японд дайн зарласан.
 D. 1945 оны 8 сарын 10-нд БНМАУ Японд дайн зарласан.
 E. 1945 оны 2 сард Ялтад гурван их гүрний уулзалт болсон.
45. Соёлын довтолгоо хэдэн оноос эхэлсэн бэ? (1 оноо)
 А. 1981 он В. 1956 он С. 1966 он D. 1959 он E. 1961 он
46. Шинжлэх ухаан, техникийн хөгжилд аль нь хамаарах вэ? (1 оноо)
 А. 1970 он гэхэд хүн амын 89,3% нь бичиг үсэг тайлагдсан.
 В. Сургуулийн бүтцийг 3+5+2 болгон өөрчилсөн.
 С. Монголын эрдэмтэд сансар судлалын “Интеркосмос” программыг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцсон.
 D. 1988 онд “Мандухай сэцэн хатан” кино дэлгэцнээ гарсан.
 E. 1968 оны Мехикогийн олимпын тоглолтоос 1 алт, 3 хүрэл медаль хүртсэн.
47. БНМАУ 1965 онд Франц улстай дипломат харилцаа тогтоосон. Энэ жил дипломат харилцаа тогтоосны хэдэн жилийн ой вэ? (2 оноо)
 А. 59 жилийн ой В. 57 жилийн ой
 С. 58 жилийн ой D. 61 жилийн ой E. 50 жилийн ой
48. Социалист системийн бүрэлдэхүүнд багтаж байсан улс аль нь вэ? (2 оноо)
 А. Дани В. Баруун Герман
 С. Их Британи D. Франц E. Зүүн Герман
49. Ховдын Багшийн Дээд сургуулийн хэсэг залуус, багш, оюутнууд хэзээ улс төрийн жагсаал цуглаан зохион байгуулсан бэ? (1 оноо)
 А. 1990.02.18 В. 1989.12.10
 С. 1990.01.21 D. 1989.12.07 E. 1990.03.07
50. Аль түүхэн үйл явдлаар БНМАУ-д олон намын тогтолцоо бий болох эхлэл тавигдсан бэ? (2 оноо)
 А. 1990 оны 3 сарын 22-24-нд хуралдсан АИХ-ын чуулган, МАХН бол “төр нийгмийг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин мөн” гэсэн үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгосноор
 В. 1990 оны 3 сарын 12-14 нд болсон МАХН-ын бүгд хурлаар улс төрийн товчоо, нарийн бичгийн дарга нарыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулснаар
 С. 1990 оны 3 сарын 9-ний орой нам, төрийн тэргүүн Ж.Батмөнх ард түмэндээ хандан радио, телевизээр орон даяар мэдээлэл хийснээр
 D. 1990 оны 3 сарын 7-ны өдрийн 14 цагт МоАХ-ны 10 гишүүн Сүхбаатарын талбайд улс төрийн тэмцлийн хурц хэлбэр болох өлсгөлөн зарлан тэмцсэнээр
 E. 1990 оны 2 сарын 18-нд Монголын ардчилсан намыг эмхлэн байгуулснаар



51. Монгол улс шинэ Үндсэн хуулиа хэзээ баталсан бэ? (1 оноо)
А. 1996 оны 6-р сарын 30
В. 1990 оны 4-р сарын 27
С. 1990 оны 7-р сарын 22
D. 1992 оны 1-р сарын 13
E. 1991 оны 1-р сарын 31
52. Шинэ үндсэн хуулиар хууль тогтоох эрх мэдлийг төрийн ямар институт хэрэгжүүлэх болсон бэ? (1 оноо)
А. Улсын хурал
В. Улсын бага хурал
С. Улсын их хурал
D. УБХ-ын тэргүүлэгчид
E. Ардын их хурал
53. Монголын төр 1996 онд ард түмнээсээ уучлал гуйж, 9 сарын 10-ыг ямар тэмдэглэлт өдөр болгосон бэ? (1 оноо)
А. Олон улсын хүний эрхийн өдөр
В. Монгол бахархлын өдөр
С. Эх орончдын өдөр
D. Хэвлэлийн эрх чөлөөний өдөр
E. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр
54. Ардчилсан хувьсгалын үр дүнд үндэсний үзэл, ухамсар сэргэснийг илэрхийлэх баримт аль нь вэ? (2 оноо)
А. Спортын салбарт тив, дэлхийн аваргууд олноор төрсөн.
В. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль” баталсан.
С. 1993 онд Бурхан багшийн чандрыг Монголд залсан.
D. 1990 онд “Монголын нууц товчоо” зохиогдсоны 750 жилийн ойг тэмдэглэсэн.
E. Электрон технологи бүтээж, цахим сүлжээ чөлөөтэй ашиглах болсон.
55. Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт юу вэ? (1 оноо)
А. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх
В. НҮБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
С. Өрнө, дорнын хөгжингүй орнуудтай найрсаг харилцаатай байх
D. Азийн улсуудтай найрсаг харилцаатай байх
E. “Гуравдагч хөрш” улсуудтай найрсаг харилцаатай байх
56. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү
Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь-ыг хангах үндэс билээ. (1 оноо)
А. Мэдээллийн аюулгүй байдал
В. Дотоод аюулгүй байдал
С. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал
D. Хүний аюулгүй байдал
E. Эдийн засгийн аюулгүй байдал



ХОЁРДУГААР ХЭСЭГ**Санамж:**

- а. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.**
- б. Зөв хариулт бүр нэг оноотой.**

2.1. Монголын өвөг түүхийн үед холбогдох нээлт болон дурсгалуудыг хамрах үетэй нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|-------------------|---------------------------------|
| а. Гал | 1. Мезолит |
| б. Нум сум | 2. Неолит |
| с. Хэл яриа | 3. Дунд палеолит |
| д. Шавар ваар | 4. Хүрлийн үе, түрүү төмрийн үе |
| е. Нарийн гол 17Б | 5. Дээд палеолит |
| ф. Буган хөшөө | 6. Доод палеолит |

2.2. Чингис хаантай холбогдох үйл явдлуудыг он цагтай нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|--|------------|
| а. Тэмүжин Мэргидийн довтолгоонд өртөж, Бөртийг алдав. | 1. 1203 он |
| б. Хар зүрхний Хөх нуурт Монгол улсын хаанд өргөмжлөв. | 2. 1189 он |
| с. Далан балжудад болсон байлдаанд Чингис хаан ялагдав. | 3. 1196 он |
| д. Улз голд Татар аймгийг бут цохив. | 4. 1190 он |
| е. Хүйтэн хэмээх газарт Гүр хан Жамухын цэргийг бут цохив. | 5. 1179 он |
| ф. Чингис хаан Хэрэйд улсыг мөхөөв. | 6. 1201 он |

2.3. Түүхэн нэр томьёонуудыг зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|---------------------|---------------|
| а. Халх Монгол | 1. Засагт хан |
| б. Өвөр Монгол | 2. Нурхач |
| с. Арын долоон отог | 3. Цорос |
| д. Манж | 4. Ордос |
| е. Дөрвөн Ойрад | 5. Гэрсэнз |
| ф. Хотгойд | 6. Шолой Уваш |

2.4. Түүхэн үйл явдлын он цагийг тохируулахдаа 1-8 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. /2 өгөгдөл илүү байгааг анхаарна уу/ (6 оноо)

- | | |
|--|-------------------------|
| а. Барон Унгерн Нийслэл хүрээг чөлөөлөв. | 1. 1921 оны 7 сарын 8 |
| б. Ардын түр засгийн байгуулагдав. | 2. 1921 оны 3 сарын 1-3 |
| с. Хиагтийг чөлөөлөв. | 3. 1921 оны 2-р сард |
| д. Богдыг хэмжээт эрхт хаанаар өргөмжлөв. | 4. 1921 оны 3 сарын 13 |
| е. МАН байгуулагдав. | 5. 1921 оны 2 сарын 4 |
| ф. Д.Сүхбаатарыг цэргийн жанжнаар томилов. | 6. 1921 оны 3 сарын 18 |
| | 7. 1921 оны 3 сарын 17 |
| | 8. 1921 оны 7 сарын 11 |

